



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 08 өдөр

Дугаар А/157

Зуунмод

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29.1.6 дугаар зүйлийн “а”, “ж”, “л”, 29.2, 30 дугаар зүйлийн 1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.4 заалт, 11.2, 11.3.3, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалтыг, тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын харьяа “Ахмад амралтын газарт” тусгаарлагдсан иргэдэд тавигдах хяналт, үүрэг гүйцэтгэж албан хаагчдын эрүүл мэнд, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүрт авч мэргэжил арга зүйн заавар, зөвлөмжийг тогтмол өгч ажиллахыг Онцгой байдлын газар (Н.Төмөрбаатар), Эрүүл мэндийн газар (С.Мөнхтуяа) нарт, тусгаарлах байрны ариутгал халдваргүйтгэлийг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангаж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (У.Өлзийцэцэг), Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (Д.Батцэцэг) нарт тус тус үүрэг болгосугай.

2. Тусгаарлан ажиглалтад байгаа иргэдийн хоолны зардал, тусгаарлах байранд үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын хоол, томилолтын зардлыг хавсралтаар баталсугай..

3. Нийт шаардагдах зардал 5,880,000 (таван сая найман зуун наян мянга) төгрөгийн 1,088,000 төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 4,792,000 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Сурмаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Аймгийн Засаг даргын 2021 о
03 дугаар сарын 02-ны өдөр
А/ХС/ тоот захирамжийн хавср



**ТУСГААРЛАХ БАЙРАНД ТУСГААРЛАГДСАН ИРГЭДИЙН ХООЛ, ТҮҮНД АЖИЛЛАХ
АЛБАН ХААГЧДЫН ХООЛ, ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Тусгаарлах байранд ажиллах хүч					Тусгаарлагдсан иргэдийн тоо	Хоног	Хоолны зардал /16 хүн 21 хоног/		Голомтод ажиллах 3 алба хаагчийн томилолтын зардал		Хяналт тавих 3 алба хаагчийн томилолтын зардал		Бүгд шаардлагатай зардал
	ОБГазар	Цагдаагийн газар	ЭМГазар	ХХҮГазар	Бүгд			Нэг хүний нэг өдрийн хоолны зардал	Нийт үнэ	Нэг хоногт шаардагдах 1 хүний томилолт 36.000 төгрөг	Нийт үнэ	Нэг хоног шаардагдах 1 хүний томилолт 12.000 төгрөг	Нийт үнэ	
1	1	1	1	3	6	10	21	8,500	2,856,000	108,000	2,268,000	36,000	756,000	5,880,000
НИЙТ									2,856,000	108,000	2,268,000		756,000	5,880,000

ТООЦОО ГАРГАСАН :
ОБГАЗРЫН АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ,
ХОШУУЧ Г.МӨНХСОЁЛ